



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

### Уулын дугуйн тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, “Биеийн тамир, спортын тухай” хууль, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах Уулын дугуйн тэмцээнийг 2017 оны 04 дүгээр сарын 22-23-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.500.000 /Нэг сая таван зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны спортын уралдаан тэмцээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн /Э.Мөнх-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500048

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны  
даргын 2017 оны *23 дугаар* сарын *27*-ны өдрийн  
*23* дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Уулын дугуйн тэмцээнийг  
зохион байгуулах төсөв

| №    | Зардлын нэр  | Нийт дүн /төг/ |
|------|--|----------------|
| 1.   | Тамирчдын шагнал:<br>8 x 20.000 төг = 160.000 төг<br>8 x 15.000 төг = 120.000 төг<br>8 x 10.000 төг = 80.000 төг | 360.000        |
| 2.   | Багийн шагнал:   | 200.000        |
| 3.   | Шүүгчдийн зардал:<br>/15 хүн x 2 өдөр x 20.000 төг/  | 600.000        |
| 4.   | Өргөмжлөл:   | 50.000         |
| 5.   | Медаль:<br>24 x 10.000 төг = 240.000 төг   | 240.000        |
| 6.   | Анонс, цом   | 50.000         |
| ДҮН: |  | 1.500.000      |

Боловсруулсан: *Э.Мөнх-Эрдэнэ* Э.Мөнх-Эрдэнэ  
Хянасан: *О.Эрдэнэцэцэг* О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн  
А.П. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Уулын дугуйн тэмцээний  
шүүгчдийн бүрэлдэхүүн

| № | Шүүгчдийн нэрс | Албан тушаал              |
|---|----------------|---------------------------|
| 1 | Ш.Жамбал       | Ерөнхий шүүгч             |
| 2 | Э.Солонго      | Бичиг хэрэг/ Нарийн бичиг |
| 3 | Д.Адъяа        | Нарийн бичиг              |
| 4 | З.Наран        | Гараа бариа нэвтрүүлэгч   |
| 5 | Б.Заяа         | Гараа, барианы шүүгч      |
| 6 | Ш.Балжинням    | Гараа, барианы шүүгч      |
| 7 | Ж.Номиндарь    | Эмч шүүгч                 |
| 8 | Г.Дэлгэрсайхан | Хяналтын шүүгч            |